

**БНМАУ-ЫН ХАРЬАТ БОЛОХ САНАЛ ТАВЬСАН ЯПОН БОЛОН
ХЯТАД ХОЁР ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙГ ШИНЖЛЭХҮЙ
(1947, 1972 ОН)**

Ш.ГЭРЭЛ

Товч агуулга. Энэхүү өгүүлэлд Монгол улсын харьяат болохыг хүсэж бичсэн хоёр хүний өргөдлийг шинжлэх оролдлогоо толилуулж байна. Эхний өргөдлийг Дэлхийн II дайнд олзлогдож улмаар Монгол улсад 1945-1947 онд байж Ноосны үйлдвэрт галчаар ажиллаж асан, Япон улсын иргэн Ивасаки Ичиро Монголд үлдэж ажил хөдөлмөр эрхлэн амьдрахыг хүсэж, 1947 оны 3-р сарын 7-нд бичиж уламжилсан өргөдөл болно. Тус өргөдөл одоо ТЕГ-ын Тусгай Архив хадгалагдаж байна. Хоёрдох нь 1972 онд Бээжин хотноо суух Монголын элчин сайдын яамны хашааг давуулан шидсэн байсан, БНХАУ-ын иргэн Бай Гуй-шэны захидал зэрэг болно. Энэхүү баримт Гадаад Хэргийн Төв Архивд хадгалагдаж байна.

Би бээр энэхүү хоёр Өргөдлийг сийрүүлэн бичиж, тэдгээрийн агуулгыг дэлгэн тавьж улмаар тэдгээр хүмүүсийн хүсэлтийг Монгол улс хүлээн авах боломж байсан эсэх талаарх асуудлыг тухайн үед мөрдөгдөж байсан хууль дүрмийн хүрээнд авч үзсэн болно.

Түлхүүр үг: иргэн, олзлогсод, цагаач, хүсэлт, үзэл бодол, дүрэм журам

Удиртгал

Аливаа улсын иргэд гадаадад зорчих, цагаачлах эрх Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үндэсний хууль тогтоомжоос гадна тухайн иргэнийг хүлээн авах улсын дотоодын хууль тогтоомж, түүнд тавигдах нөхцөл хамаарал зэргээс шалтгаалдаг билээ.

Өнөө үед хүний эрх, эрх чөлөө улс орнуудын харилцан хамаарал, дэлхий нийтийн чиг хандлага, хөгжил, даяарчлалын эрчимжүүлэхэд цагаачлал нь чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн байдаг. Гэвч сүүлийн 2 гаруй жил дэлхий нийтийг хамарсан Ковид-19 –ийн цар тахал хүн төрөлхтний өмнө том асуулт тавилаа. Даяаршил гэх зүйл ер нь зохистой зүйл мөн үү? Ковидын дараа улс хоорондын харилцаа хийгээд даяаршил яах бол? г.м. Гэхдээ ямартаа ч улс орон бүр цагаачлалын асуудлыг зайлшгүй зохицуулах хууль тогтоомжтой байх бодлого баримталдаг нь нийтлэг байна. Гадаадад цагаачлах асуудал нь хүний эрхийн

бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг. Гэвч хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад эл асуудал өөр өөрөөр тавигдаж байсныг түүх гэрчилнэ.

Гадаадын иргэд бусад оронд зорчих зорилго, хугацаа, үйл ажиллагаа зэрэг олон зүйлээс шалтгаалан *түр болон байнга оршин суугч, цагаач, дүрвэгсэд, орогногч* гэх зэргээр ялгаж тэдгээрийн эрх зүйн байдлыг тус тусад нь тогтоосон байдаг юм. Түүнчлэн ер нь гадаадын иргэдийн асуудал нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр, олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон байдлаас ихээхэн хамааралтай.

БНМАУ-ын Засгийн газраас гадаадын иргэдтэй холбогдох дүрэм журмыг тогтоож хэрэгжүүлсээр ирсэн байна. Улсын Бага хурлаас 1941 оны 1 сард “Гадаад улсын харьяат нараас БНМАУ-д дагаар орохыг хүсэгчдийг оруулан авах тухай” дүрмийг баталсан байдаг. Энэхүү дүрмээр Монгол улсад харьяат болох статус нь харьцангуй чөлөөтэй тэгш байх, харьцангуй сонгомол байх зарчмыг тусгасан хэмээн судлаачид үздэг¹. Тус улсад 1940 оны байдлаар 6117 барга, 4909 торгууд, 50708 казах, 156811 буриад дагаар орж, тархан суурьшсан байжээ². Үүнээс харахад монгол угсаа гаралтай элэг нэгтнүүдээ дэмжих, иргэний харьяаллаа өгч байсан нь харагдаж байна. Гэхдээ наашаа харсан болгоныг хүлээж авдаггүй байсан нь Сибирьд дүрвэн очсон солонгосчуудаас тус улсад дагаар орох хүсэлт тавьж (1920-1930-аад он) байсанд татгалзсан явдлаар илэрнэ. Түүний шалтгаан бол БНМАУ-улс нь нэг харьяаллын зарчмыг баримталдаг, улс төрийн шалтгаанаар дүрвэн ирэгсэд, орогнол хүсэгчдийг зохицуулах шийдвэрлэх тухай холбогдох хууль, дүрмийг хараахан боловсруулж, батлан мөрдөөгүй, иргэний харьяаллын асуудлаар Солонгос улстай хэлэлцэн тохиролцсон гэрээг хийгээгүй зэрэгтэй холбоотой байв. Мөн тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал ч иргэний харьяаллын бодлого шийдвэрт нөлөөлж байсны илрэл болж байсны тод жишээ бол зарим буриадуудыг ЗОУ, Коминтерны бодлого, улс төрийн хилс хэрэгтэй холбоотойгоор улсынхаа харьяат болгохоос татгалзаж байсан байдаг.

1948 онд НҮБ-ийн Ерөнхий Ассамблей “Хүний эрхийн түгээмэл тунхаг”-ийг батлан гаргасан бөгөөд түүгээр бол хүн бүр доорх эрхийг эдэлнэ. Үүнд:

- Амьд явах
- Халдашгүй дархан байх
- Хэн ч бай, аль улс орныг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй
- Эх орондоо эргэж очих эрхтэй гэх зэргээр болно³.

БНМАУ энэ үед НҮБ-д элсээгүй байсан (элсэх хүсэлтийг анх 1946 онд өгсөн-Ш.Г.) бөгөөд Олон улсын Хүний эрхийн түгээмэл тунхагт нэгдэн ороогүй байсан юм.

1959 оны Сайд нарын Зөвлөлийн 18 дугаар тогтоолоор баталсан Гадаадын иргэдийн БНМАУ-ын иргэн болгох зааврыг шинэчилж, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1974 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 369 дүгээр

¹ БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох актын эмхэтгэл (1941-1970) II боть. УБ., 1974: 15

² Мэндсайхан Х. МУ дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал, УБ., 2012: 126

³ Хүний эрхийн тухай үндсэн баримт бичгүүд. УБ., 1993: 7

зарлигаар БНМАУ-ын “Харьяатын тухай хууль”-ийг баталсан байна. Энэ хууль нь 13 зүйлтэй бөгөөд тус хуулийг хэрэгжүүлэхийн тулд Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 181 дүгээр тогтоолоор БНМАУ-ын “Харьяатын хууль” биелүүлэх зааврыг баталжээ.⁴

Харьяатын хуулийн зургаадугаар зүйлд: “БНМАУ-ын харьяат болохыг хүссэн өөр улсын харьяат буюу харьяалалгүй иргэнийг эрэгтэй, эмэгтэй, арьс үндэс, шашин шүтлэгээр ялгаварлахгүй БНМАУ-ын харьяат болгоно”. Арван гуравдугаар зүйлд: “Харьяатын асуудалтай холбогдсон өргөдөл гомдлын талаар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид эцсийн шийдвэрийг гаргана” хэмээн заасан байна.

1960 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн Т-д Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нь: “БНМАУ-ын иргэн болгож авна. Мөн БНМАУ-ын иргэнээс гарахад зөвшөөрөл олгоно”⁵ гэсэн ерөнхий заалт орсон байдаг.

Ингээд гадаадын иргэн БНМАУ-д дагаар ороход дээрх дүрэм болон хуулийн дагуу асуудлыг авч хэлэлцэж байсан байна. Гэвч: Тогтоосон хууль журмын дагуу шийдвэрлэж болохооргүй тохиолдлууд гарч байсан байна. Үүнийг доорх хоёр жишээгээр төлөөлүүлж харуулъя.

Япон цэргийн өргөдөл (1947.3.7)

Дэлхийн II дайны төгсгөл болох Азийг чөлөөлөх дайнд Монгол ардын арми Зөвлөлтийн армийн хамт оролцож ялалт байгуулсан билээ. Зөвлөлтийн тал Чөлөөлөх дайны үеэр 609448 япон хүн олзолсон бөгөөд түүнээс 12318 хүнийг Монголд байршуулахаар илгээсэн юм. Эдгээр олзны хүмүүс дотор цэргээс гадна энгийн хүмүүс мөн байсан байна. Эдгээр олзны хүмүүс БНМАУ-д 2 жил албадан хөдөлмөр эрхэлж байгаад 1947 оны намар эх орондоо буцсан байдаг. Япон олзны хүмүүсийн нэг болох Ивасаки Ичиро гэгч цэрэг Монголд үлдэх хүсэлтээ илэрхийлэн нэгэн бичиг үйлдсэн бөгөөд тэр нь өдгөө Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын тусгай Архивын сан хөмрөгт хадгалагдаж байна⁶. Энэхүү өргөдлийг анх түрүү олж үзэж, түүний тухай бичсэн хүн бол МУИС-ийн Түүхийн тэнхимийн магистрант Б.Эрдэнэбилэг байв. Тэрбээр Япон олзны цэргүүдийн талаар судалгаа хийж магистрын ажлаа бичсэн байна. Дараа нь түүхч Ж.Урангуа, Б.Эрдэнэбилэг нар “Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд” гэх номд өргөдлийг бүрэн эхээр нь хэвлүүлжээ⁷. Би энэхүү өгүүлэлд дээрх номоос авч толилуулж байна.

Ингээд япон цэргийн өргөдлийг дэлгэвээс:

⁴ Давааням А., Мэндсайхан Х., Нэргүй Ц, ГИХАЭА-ны тогтолцоо, УБ., ЖСК, 2008: 80

⁵ Амарсанаа Ж. Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ., 2012: 453

⁶ ТЕГ.Тусгай архив. Сан 1, хадгаламжийн нэгж 592: 1-2

⁷ Урангуа Ж., Эрдэнэбилэг Б. Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд. УБ., 2018: 124-129

Түүхт байдал: 1921 оны 11 сарын 1-нд Осака хот баруун хуваарийн Манами Хорикама гудамжны 2-ын 17 тоот байшинд төрсөн. Эцэг Ивасаки Асакижи, эх Ивасаки Томиёо. Эцэг нутагтаа худалдаа хийж байлаа.

1928 онд бага сургуульд орохын тулд Окаяма префектурийн Хижүки уездийн Ханатаки хотын Ёжи-и хэмээх газрын Ё-и 39 дүгээр байшинд /эхийн, эцгийн гэр/ миний бие эхийн хамт нүүн очсон болой. Эцэг Осака хотдоо жижиг юмны худалдаагаа хийж байв.

1928 оны 4 сарын 1-нд Ёжи-и хэмээх бага сургуульд оров. 1930 оны 4 сарын 1-нд эцэг уушгины өвчнөөр нас барав. 1934 оны 6 дугаар сард 6 жилийн бага сургуулийг төгсөв. Мөн оны мөн сард Нара префектурийн Такажи уездийн Има-и жижиг хотын Накасофу гэдэг газрын 2 дугаар тоот байшинд эхийн хамт нүүсэн бөгөөд эх нарийн боовны худалдаа хийх болов. Мөн жилийн 4 сард Нара пробикторын Тинки хэмээх дунд сургуульд суралцав. 1939 оны 3 сард мөн Тинки дунд сургуулийг төгссөн.

Мөн жилийн мөн сард хойд Хятадын Тимежү ангийн цэргийн энгийн албан хаагчаар мөн оны 3 сарын 31-нд авав. Мөн оны 4 сарын 10-ны өдөр Хятадын нутагт хүрлээ. 1940 оны 3 сар хүртэл Үмайса ангид даргын жолооч хийж байсан. 1940 онд 3 сарын хугацаа гүйцсэн тул нутагтаа буцаж, Нарахин, Таканчикүн, Имаичү, Нагособо /Нагособу/ 2 дугаар газарт хар ажил хийв.

1941 оны 5 сард цэрэгт татсан тул комисс биеийн байдлыг Осака хотын Найсикү газарт шалгасан болно. 1942 оны 1 сарын 10-ны өдөр Осака хотын Чүбү газрын 22 дугаар ангид цэрэгт татагдлаа. 4 сарын 15-ны өдөр Осака хотоос Манжуурын зүг явав. Мөн сарын 25-ны өдөр Тоиншү, Мисашихин, Нинхин-д 180 дугаар ангийн 3 дугаар суманд цэрэг болов. 7 дугаар сарын 10-ны өдөр 1 дүгээр цэрэг болов. 1943 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр ахлах цэрэг болов. 7 сарын 1-ний өдөр Манжуурын нийслэлд Жандарм цэргийн боловсрол ангийн 1-р суманд орлоо. Мөн сарын 10-ны өдөр цэргийн ахлагч болов. 1944 оны 4 сарын 20-ны өдөр сургууль төгслөө. 7 сарын 1-ний өдөр 1 дүгээр сумангийн 7 дугаар тасгийн даргын орлогчоор цэргийн сургаал заасан. 12 сарын 1-ний өдөр Жандарм цэргийн тасгийн дарга болов. 1945 оны 4 сарын 1-ний өдөр Инжоү хотын жандарм цэргийн тасгийн орлогчоор мөн сарын 8-ны өдөр тус хотод хүрч ирлээ. Мөн сарын 9-ний өдөр Инжоү хотын жандарм цэргийн салааны ангид цэргийн хувцасны эрхлэгчийн ажлыг олзлогдсон өдөр хүртэл хийсэн.

1945 оны 8 сарын 15-ны өдөр бууж өгсөн тул тус хотын Манжуурын 804 дүгээр ангийн цэргийн байранд шилжсэн. Мөн сарын 14-ний өдөр Жандарм цэргийн түрүүч болсон. Мөн өдөр нисэх онгоцны буудлын газарт шилжсэн. 1945 оны 9 сарын 20-ны өдөр морины хашааны ажил хийв. 10 сарын 13-ны өдөр Номора /Нумура/ ангид шилжин орж, 14-ний өдөр Кошин хотод хүрч ирээд цахилгаан гаргах газарт ажиллахаар болов.

11 сарын 6-ны өдөр Кошин хотоос гарч яваад 26-ны өдөр Хужирбуланд ирээд 12 сарын 12-ны өдөр Амгаланд шилжсэн. 1946 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 2 дугаар суманд ороод дээд сургуулийн барилгын ажил хийсэн. 2 сарын

28-ны өдрөөс лагерийн даргад конторын цэвэрлэгч хийлээ. 4 сарын 6-ны өдөр Ноосны фабрикт шилжсэн. 5 сарын 18-наас одоо хүртэл даргын жолооч болоод байшингийн дотор элдэв төрлийн ажил хийж байна.

Намайг цэрэгт татагдаад удаагүй байхад ээж Окаяма хотын Амасай 107 дугаар газрын дэлгүүрт ажиллаж байгаад, 1944 оны 11 дүгээр сараас хойш захиа ирэхгүй болов. Үүнээс урьд сар тутам 2 удаа захиа ирдэг байсан. 11 дүгээр сарын захианд бичсэнээр бол Тужиу хотод сууж байгаа эцгийн эрэгтэй дүүгийн гэр байгаа газарт бөмбөг хаяж, эхнэр нь үхсэн гэж бичсэн байсан. Би эндээс хэдэн удаа захиа бичсэн боловч хариу ирээгүй. Окаямад олон удаа бөмбөг хаясан байна. Тийм учраас би ээжийг үхсэн байх гэж бодож байна. Миний эрэгтэй дүү эхийн гэрээс сургуульд явж байгаад цэргийн энгийн алба хааж, заводод шилжсэн. Эх, эрэгтэй дүү нар байгаа уу, үгүй юу мэдэхгүй. Бараг бөмбөгт үхсэн болов уу гэж бодож байна. Би Манжуурын нийслэлд шилжсэн тул амьд байна. Надтай 180 дугаар ангиас цэрэгт татагдсан хүмүүс 1943 оны зун дайнд бүрэн үхсэн билээ. Миний дайны нөхөд бүрэн үхсэн тул би хэзээ ч үхэж болно гэж санагдаж байна. Бууж өгсөн хойно миний үхэх санааг зогсоож билээ. Би нутагтаа буцахгүй. Цэргээс салж Манжуурт ажил хийх санаа байвч дураар яавч болохгүй тул цэрэгтэй цуг ирсэн билээ. Япон сонин дээр бичиж байгаа нь япончууд гадаад улсад байгаа хүмүүст нутагтаа буцаж идэх хоол, хийх ажил байхгүй гэж бичиж байна. Ийм учраас Монгол улсад суувал сайн гэж санаа орлоо.

Ноднин жилийн 10 сараас ийм бодол эргэлдэж байна. Ойрын өдрөөс лагерьт байгаа япончууд нутагтаа буцна гэж их ярьж байна. Сонин ба радиогоор зарлаж, 5 дугаар сард нутагтаа буцах нь үнэн гэж итгэмжтэй байна. Нутагтаа буцаад гэр бүл ба хийх ажил байхгүйг бүү мэднэ. Ийм учраас Монгол улсад ажил хийж болох бол намайг хоцруулж авахыг гуйя. Сэтгэлийн угаас гуйж байна. Намайг энд суулгах арга хэмжээ авахыг хүсье. 1947 оны 3 дугаар сарын 7-ны өдөр. Ивасаки Ичиро⁸ гэжээ.

Ивасаки Ичирогогийн бичгээс үзэхэд тэрээр Осака хотод төрсөн, ерөнхий боловсролын сургууль төгссөн ба тодорхой мэргэжил эзэмшээгүй, тиймээс цэвэрлэгч, барилгын ажил, жолооч зэрэг элдэв төрлийн ажил хийж байжээ. 1941 онд цэрэгт татагдан Манжуурт алба хааж байхдаа цэргийн сургуульд суралцаж улмаар Манжуурын нийслэлийн Жандарм цэргийн газар ажиллаж байгаад дайны төгсгөлд олзлогджээ.

Тэр сонин хэвлэлд бичсэн зүйлээс дайнд ялагдсан эх орон нь хүнд байгаа талаар уншиж, улмаар гэртээ харихад гэр бүл нь үгүй болсон байх магадлалтай мөн ажил олдох нь эргэлзээтэй гэж өөрөө үзсэн учраас Монголд үлдэж ажил хийн амьдрахыг хүсжээ.

Уг өргөдлийн дагуу 1947 оны 3 сарын 21-нд ДЯЯ-ны ахлах төлөөлөгч С.Лодонгаваа V фабрикийн лагерийн олзлогдсон цэрэг, конторын галч Ивасаки Ичиротой ярилцсан байна. Тэгэхэд Ивасаки Ичиро Монголд үлдэх талаар япон дарга нартаа мэдэгдээгүй, хэнтэй ч зөвлөлдөөгүй, зөвхөн өөрийн хүслээр эл

⁸ Урангуа Ж., Эрдэнэнбилэг Б. Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд. УБ., 2018: 124-127

өргөдлийг бичсэн. Тэрээр өөрийгөө ард түмэн нь тэгш эрх чөлөөтэй, эв хамтын засагт дуртай гэхэд төлөөлөгч С.Лодонгаваа: "Ямар нэг хүн өөрийн өссөн төрсөн нутгийг орхиж өөр нэг улсад хүн танихгүй, газар мэдэхгүй, хэл яриа, заншил мэдэхгүй байж амьдран сууна гэдэг асуудал бол туйлын хэцүү бөгөөд хэн хүний санаанд орохгүй бодлого юм. Гэтэл та өөрийн өссөн төрсөн нутгаас хэрхэн юуны учраас ийнхүү салахыг бодсон юм бэ?" гэхэд тэрээр дайны дараа Японд хүнд байх болов уу? Тиймээс нэгэнт Монголд ирчихсэн юм чинь энд үлдэх хүсэлтэй, ямар ч ажил хийж чадна, би нутагтаа боорцог, талх зэрэг боовны зүйлийг хийж байсан тул тэр ажлаа хийх дур хүсэлтэй байдаг юм хэмээн мэдүүлжээ.

С.Лодонгаваа цааш нь: "Та бол Монголын харьяат болох хүсэл эрмэлзэлтэй хүн учир биднийг итгэж улмаар бидэнд дүүрэн итгэгдэх ёстой хүн мөн биз дээ? гэж асуухад хариулт нь "би бол та нөхдийг дүүрэн итгэж байна. Ийм учраас би та нөхдийн хий гэсэн ажлыг хийж байж чадна. Тэр чанараараа би та нөхдөд итгэгдэх ёстой юм" хэмээжээ.⁹

Энэхүү Ивасаки Ичиро бол энгийнээр Монголд оршин сууж байсангүй, тэрээр дайнд олзлогдон ирсэн агаад олзлогсдын хуаранд хараа хяналт дор, албадан хөдөлмөр эрхэлж байсан учир түүний эл байдал нь жирийн оршин суугчаас ихээхэн ялгаатай учир Монголын харьяат болон үлдэх саналыг хүлээн авах ямар ч боломжгүй байсан. Өгүүлэн буй үед мөрдөж байсан Гадаадын харьяат хүн Монгол улсын иргэн болох тухайд баримталж байсан шалгуурууд ч япон эрийн байдалд нийцэхгүй байв. Учир нь тус улсын харьяат болохын тулд Монголд 10-аас доошгүй жил оршин суусан, ажил хөдөлмөр эрхэлдэг байх, мөн монгол бүсгүйтэй гэрлэсэн байвал харьяат болох асуудлыг авч хэлэлцдэг байв.

Түүний өргөдлөөс хоёр зүйл ажиглагдана. Нэгд, Монголд түүнд ажил олдоно гэж үзжээ. Тэр эх орондоо байхдаа талх, боорцог, нарийн боов зэргийг хийдэг байсан. Одоо Монголд үлдвэл энэ ажлаа хийж чадна гэдгээ илэрхийлсэн байна. Хоёрт, социалист коммунист үзэл санааг дэмждэг гэж хэлсэн нь түүний жинхэнэ үзэл бодол байв уу? Эсвэл ингэж хэлбэл түүний хүсэлтийг дэмжих болов уу, гэсэндээ тэгж тайлбар өчив үү? Учир нь тэр улс төрийн орогнол хүсээгүй байна.

Эцэст нь тэрээр эх оронд нь ар гэрийнхэн нь ер нь амьд үлдээгүй болов уу? гэсэн таамаг хэлж, тиймээс Монголд үлдэхийг хүсэж байна гэсэн нь тэрээр тус оронд үлдэх гэсэн шалтгаанаа олон болгох гэж л тэгж бичсэн бололтой. Ингээд Монголын тал түүний хүсэлтийг хүлээн аваагүй бололтой, тэр бусад олзны хүмүүсийн хамт эх орондоо харьсан бололтой гэж түүхч Урангуа болон Эрдэнэбилэг нар бичжээ¹⁰.

Жич: БНМАУ тэр үед дайны олзлогдогсдын талаарх олон улсын гэрээ, тунхагт нэгдэн ороогүй байсан үе. Тус улс нь 1958 онд "Дайнд нэрвэгчдийг хамгаалах тухай" Женевийн конвенциүдэд нэгдэн орсон байдаг.¹¹

⁹ Урангуа Ж., Эрдэнэбилэг Б. Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд. УБ., 2018: 127-129

¹⁰ Урангуа Ж., Эрдэнэбилэг Б. Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд. УБ., 2018: 129

¹¹ УТА, хөмрөг 383, д.1, хн.7

БНХАУ-ын иргэн Бай Гуй-шэний өргөдөл (1972, 12 сар)

Хятадад хаягдсан монгол хүн Бай Гуй шэн гэсэн гарын үсэгтэй энэхүү захидлыг 1972 оны 12 дугаар сард БНМАУ-аас Бээжин хотноо суух элчин сайдын яамны хашааг давуулан хаясан байжээ. Тус Өргөдлийг хятад хэлнээс О.Адьяа, Г.Бэхбат нар орчуулжээ. Өдөө тус баримт Монгол Улсын Гадаад хэргийн төв Архивын сан хөмрөгт хадгалагдаж байна¹². Энэ захидлын талаар бичсэн зүйл одоогоор ер гараагүй байна.

Ингээд уг бичгийг илтгэвээс:

БНМАУ-аас Хятадын Бээжинд суугаа Элчин Сайдын Яаманд

Юуны өмнө та нөхдөд халуун дотно мэндчилгээг дэвшүүлье. Миний нэр Бай Гуй-шэн, би монгол хүн, нас 35, эрэгтэй. Миний бие Бээжингийн Хай Дянь районы Хуо Чи Ин тосгоны Чжэн Хуан Люй 77 номерт оршин буудаг. Би Бээжингийн радио хүлээн авагчийн 3-р үйлдвэрт ажилладаг. Уугуул нутаг-БНМАУ-д очих хүсэлтэй. Би бол хятадад хаягдсан монгол хүний үр сад юм. Миний гурван үе хятадчилагдсан. Би үндэснийхээ хэл соёлыг мэдэхгүй.

Харин үндэстнийхээ түүхийн талаар хагас дутуу мэдлэгтэй. Үндэстнийхээ зан заншлыг мартсан хүн. Гэвч би өөрийнхөө үндэстнийг мартаагүй байна. Тийм ч учраас хятадад хаягдсан хэвээр үлдэхийг хүсдэггүй юм. Би өөрийнхөө үндэстэнд маш халуун хайртай. Миний үндэстний улс-БНМАУ-ыг би бишрэн санагалзаж байдаг.

Хятадад хэдийгээр монгол цөөн тоот үндэстэн байдаг боловч хятадын 2000 жилийн түүхээс аваад үзэхэд монгол үндэстэн хэзээнээсээ хятадын хойд хилийн гадна орших өөр улс үндэстэн байжээ.

Хятадын түүхэнд Цунь Чиу дайнч улсын үеэс эхлэн хятадын хойд хилийг гадаадын улс үндэстэн Хүннү нүүдэлчин аймгуудаас хамгаалж байсан тухай тэмдэглэгдсэн байдаг. Энэ нь түүхийн баримт баталгаа, түүхчдийн нотолгоогоор тодорхой болсон зүйл юм. Түүхэнд тэмдэглэгдсэн энэ баталгаатай зүйлийг хэн ч үгүйсгэхгүй.

XVII зууны эхэн үеэс манай үндэстэн манжид байлдан дагуулагдсаны дараа түүнд эзлэгдэх, тэр үеийн Хятадын Мин улсын хаан төр ч гэсэн унасан билээ. 300 жилийн түүхийн хувьсал, өөрчлөлтөөр манай үндэстэн хагаран бутарч мөхсөн юм.

Октябрийн хувьсгалын ялалт, монгол үндэстэнд тусгаар тогтнолыг авчирч БНМАУ-ыг байгуулсан билээ. /Тэр үеийн хятадын засгийн газар Чжан Кай-шийн цэргийн эрхтнүүд одоо хүртэл манай улс үндэстний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй саатуулсаар ирлээ. Тэд их үндэстний бодлогыг хүчтэй явуулж ирсэн юм./

Гэвч одоогийн БНМАУ-ын XVII зууны үеийн тэртээх газар нутаг нь хомсдож, хил хязгаар нь их хэмжээгээр багассан бөгөөд үндэстэн нь хуваагдан

¹² ГХТА, Ф-02, д.2, хн 422.х 9. Бээжингийн элчин сайдын яамны хашаанд хаясан захидлын тухай. 1972 он

салжээ. Энэ бол түүхэнд империализм, феодализм хоёр хүчин хавсарч түрэмгийлж байсны хор уршгаас болсон юм. Одоогийн хоёр орны харилцааг бодож өнөөгийн хятадын засгийн газрыг би муучлахыг хүсэхгүй байна. Гэвч үндэстэн бүр өөрийнхөө дур сонирхлын дагуу ямар үндэстэн байхаа шийдвэрлэж болох ёстой билээ. Монгол үндэстний түүхийн онцлог байдлаас үндэслэн хятадын дотор байгаа манай үндэстэн өөрсдийнхөө сайн дураар аль улсын харьяат болохыг шилж сонгох ёстой.

Дээрх учир шалтгаанаас болон үндэстний сонирхол, эх орондоо хайртай байх үүднээс би хэдийгээр өөр оронд хаягдаж орхигдсон боловч өөрийн үндэстний хэл соёлд халуун хайртай байдаг. Тийм ч учраас манай үндэстний цорын ганц улс-БНМАУ-д буцаж очих хүсэлтэй байдаг юм. Үндэстнийхээ улс орны социалист бүтээн байгуулалтын ажилд би баяр баясгалан, аз жаргалтай, урам зоригтой оролцох хүсэл эрмэлзэл дүүрэн байна. Манай үндэстний яс махны тасархай зарим ястнууд өөр үндэстэнд уусаж үндэсний соёл, түүх, хэлээ мартсан явдлыг та бүхэн тэсвэрлэхгүй бизээ.

Үндэс угсаагаа хайрласан, эх орноо мөрөөдсөн миний энэ хүсэл биелэх эсэхийг мэдэхгүй байна.

Та бүхнээс надад тусламж дэмжлэг үзүүлэхийг хүсье. Эх орондоо буцаж очиход түр саад тохиолдож, зорилго маань биелэхгүй байлаа ч гэсэн би өөрийнхөө мөрөөдлийг хэзээ ч орхихгүй. Үүний зэрэгцээгээр надад үндэснийхээ хэл, соёл, түүхийг суралцахад минь туслахсан болов уу. Элчин сайдын яамны хүмүүс надад бүх хүчээрээ тусалж дэмжихийг хүсье. Та нөхөд яаралтай хариу захидал ирүүлж надтай холбоо барина уу? Нэг үндэсний ах дүү нартайгаа уулзах, сэтгэл санааны үгээ ярилцах юмсан. Элчин сайдын яамны бүх хүмүүст мэндийг уламжилж өгнө үү. Та нараар дамжуулан монголын ард түмний эх орон-БНМАУ-д баяр хүргэе. Монгол үндэстний цорын ганц улс-БНМАУ мандтугай.

Хятадад хаягдсан монгол хүн
Бай Гуй-шэн”¹³

Энэхүү захидалд дурдсан зүйлийг ажиглаваас: өмнөд монголчууд хятадчилагдсан, тийм хүмүүсийн үр сад тэр өөрөө бөгөөд хэл соёлоо мэдэхгүй болсон гэхдээ уг түүхээ сонирхдог учраас монгол, хятад хоёр бол угаасаа өөр өөр үндэстнүүд гэсэн зөв ойлголттой байсан нь тодорхой байна. 1972 он гэдэг бол Монгол, Хятадын харилцаа 1967 оноос таслагдаад удаагүй байсан үе ба Хятад дахь соёлын хувьсгалын¹⁴ хэнээрхлийн 3 дугаар үе явагдаж байсан үе юм. Хятадад Монголын түүхийг гуйвуулах явдал ид гаарч байсан үе байв.

Бай Гуй-шэн өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ: “...үндэстэн бүр өөрийнхөө дур сонирхлын дагуу ямар үндэстэн байхаа шийдвэрлэж болох ёстой билээ. Монгол үндэстний түүхийн онцлог байдлаас үндэслэн хятадын дотор байгаа манай үндэстэн өөрсдийнхөө сайн дураар аль улсын харьяат болохыг шилж сонгох ёстой.

¹³ ГХТА, Ф-02, д.2, хн 422. х.11

¹⁴ БНХАУ-д Соёлын хувьсгал 1966-1976 онд өрнөсөн.

Дээрх учир шалтгаанаас болон үндэстний сонирхол, эх орондоо хайртай байх үүднээс би хэдийгээр өөр оронд хаягдаж орхигдсон боловч өөрийн үндэстний хэл соёлд халуун хайртай байдаг. Тийм ч учраас манай үндэстний цорын ганц улс-БНМАУ-д буцаж очих хүсэлтэй байдаг юм” гэсэн нь чухамдаа өөрийнхөн үзэл бодол байсан, эсвэл үүгээр халхавч хийж тагнан турших үйлдэл ч байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Мөн тэрбээр: “Үндэстнийхээ улс орны социалист бүтээн байгуулалтын ажилд би баяр баясгалан, аз жаргалтай, урам зоригтой оролцох хүсэл эрмэлзэл дүүрэн байна. Манай үндэстний яс махны тасархай зарим ястнууд өөр үндэстэнд уусаж үндэсний соёл, түүх, хэлээ мартсан явдлыг та бүхэн тэсвэрлэхгүй биз ээ-“ гэж бичсэн нь чухамдаа умардын монголчууддаа хайртай даа юу? эсвэл өмнөд монголоо Хятадад алдсан нь умардынхны буруу гэсэн санаа агуулагдсан мэт үзэгдэнэ.

Тэрээр цааш нь бас нэг хувилбар санал болгосон нь монгол үндэснийхээ хэл, соёл, түүхийг суралцахад нь тусламж үзүүлээч гэжээ.

Улмаар тэр элчин сайдын яамныхантай нүүр учран уулзаж, сэтгэл санааны үгээ хэлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Соёлын хувьсгалын үеэр Хятадын улаан хамгаалагчид Монголын элчин сайдын яамны машин руу халдсан зэрэг дипломат ажиллагаанд байж боломгүй ноцтой хэрэг гарсан байсан бөгөөд Элчин сайдын яам сонор сэрэмжтэй байж, гаднын хүнийг нэвтрүүлэхгүй байсан үе байв. Тиймээс уулзах боломж олгоогүй, энэ захидлын мөрөөр ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй бололтой. Тийм боломж ч тухайн үед ер байгаагүй байна.

Дүгнэлт

Иргэний харьяалал нь Төр ба Иргэн хоёрыг холбож буй улс төр, эрх зүйн тогтвортой холбоос байдаг. Харин энэхүү холбоосны агуулга нь төрийн зүгээс баталгаажуулж өгсөн иргэний эрх, эрх чөлөө, төрийн өмнө хүлээх үүргийг олон улсын хэм хэмжээнд уялдуулсан үндэсний хууль тогтоомж, эрх зүйн бусад актаар зохицуулагддаг байна.

Иргэний харьяалалтай болох, харьяаллаа алдахтай холбогдсон бүх асуудал нь улс гүрний тусгаар тогтнолтой холбоотойгоор тэдгээрийн үзэмжээр зохицуулагдаж байдаг хүний эрхийн чухал асуудал хэмээн үздэг. Иргэний харьяаллын зохицуулалт нь улсын Үндсэн хууль болон тусгайлсан хууль дүрмээр зохицуулагддаг бөгөөд түүхэн хөгжлийнхөө явцад ялимгүй хувьсан өөрчлөгдөж, улам бүр төгөлдөржиж байдаг жамтай.

Түүхийн судалгаа нь харьяатын тухай хууль дүрэм хэдийд яаж өөрчлөгдөн хувьссан, мөн харьяатын тухай хууль амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байсныг судалдаг билээ. Гадаад улсын харьяат хүнийг тухайн улсын харьяат болгох асуудал бол нарийн нухацтай хандах, тухайлан заасан хэм хэмжээний хүрээнд хязгаартайгаар шийдэгддэг асуудал юм. Тиймээс өргөдөл хүсэлт тавьсан хүн бүхний асуудлыг авч хэлэлцэх ёсон үгүй. Тийм тохиолдлын жишээ бол дээрх хоёр хүний өргөдөл юм.

“Иргэн” хэмээх нэр томьёо Францын Аугаа Их хөрөнгөтний хувьсгалын ялалтын дараа, 1789 оны Хүний эрх ба иргэний эрхийн тухай Тунхаглалд анх баталгаажигдсан байдаг. Түүний дараахнаас энэ нэр томьёо олон улсын эрх зүйн ач холбогдолтой болж, хувь хүний эрх зүйн статус, түүний аль улсад харьяалагдахын илэрхийлэл болсон байдаг.

БНМАУ анх 1926 онд анх гадаадын иргэдийг өөрийн орны харьяат болгох тухай дүрэм зааврыг батлан гаргасан байдаг. Тэрхүү “Тус улсын хязгаарын дотор суугаа гадаад улсын харьяат нарыг дагуулан авах тухай тогтоосон дүрэм”-д, “Манай Монгол улс тус улсын нутагт суугаа гадаад улсын харьяат нарыг дагаар орохыг хүсэгчдийн шударга самууныг ялган салгаж, уул газар оронд харшлах үгүйг дагуулан авч болох тухай. Мөн монгол эхнэр аваад хүүхэд төрүүлж 5 жилээс дээш болсон хүмүүн болох аваас сайн дурын саналаар дагуулан авна. Мөн зуун хувийн нэгэн хувиас илүүгээр гадаадын хүмүүнийг дагуулан авч үл болно”¹⁵ гэж заасан байдаг. Ийнхүү харьяатаа өгөх хүний тоог хязгаарлан өгсөн байдаг нь хүн ам цөөнтэй улсынхаа хувьд баримталсан нэгэн бодлого байжээ. Энэ дүрэм журмаас хойш олон чухам баримтуудыг батлан гаргаж мөрдөж байсан ба тэдгээр нь цаг үеийнхээ нөхцөл байдалд тохирсон, улам бүр төгөлдөржсөөр ирсэн байдаг билээ.

Монгол хүнтэй гэр бүл бололцсоны улмаас тус улсын харьяат болсон хүний тоо¹⁶

он	1931	1933	1935	1936	1937	1938	1939	1940
хүн	59	14	82	7	28	4	4	6
Нийт								205 хүн

Иргэний харьяалалтай болох хэд хэдэн зам байдаг. Нэгд: төрснөөрөө иргэний харьяалалтай болох. Энэ нь “цусны эрх” ба “хөрсний эрх” гэсэн хоёр зарчимтай байдаг. Дээр өгүүлсэн хоёр хүн эл хувилбарт орохгүй этгээдүүд. Хоёрт: эрх олгох журмаар иргэний харьяалалтай болох зам. Энэхүү иргэний харьяаллыг эрх олгогдох журмаар олж авах нь тухайн хүн өөрийн санаачилгаар хүсэлт гарган, сайн дурын үндсэн дээр иргэний харьяалалтай болох явдал юм. Дээр дурдсан япон цэрэг бол жирийн оршин суугч биш, дайны олзны хүн бөгөөд тусгаарлагдсан лагерьт амьдарч, албадан хөдөлмөр эрхэлж байгаа хүн учир түүний өргөдлийг авч үзэх ямар ч боломж байхгүй байжээ. Нөгөө нэг өргөдөл гаргагч хятадын иргэний асуудалд ч мөн тухайн үеийн Монголын-Хятадын хязгаарлагдмал харилцааны үед мөн л авч хэлэлцэх боломжгүй зүйл байв. Учир нь харьяатын асуудал тухайн хүний сонголт дээр үндэслэгдэхгүй аж. Мөн бидний өгүүлэн буй үед иргэний давхар харьяалал¹⁷ гэдэг зүйл Монгол, Япон, Хятадад огт байгаагүй, одоо ч байхгүй байгаа.

¹⁵ Мэндсайхан Х.. МУ дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал, УБ., 2012. Соёмбо, х.122

¹⁶ Мэндсайхан.Х, Дурдсан зохиол. тал.126

¹⁷ Давхар харьяаллыг хүлээн зөвшөөрсөн анхны орон бол Итали-1912 онд, дараа нь Англи 1948 онд г.м.

Abstract

This article presents an attempts to analyze the applications of two foreigners who wanted to become Mongolian citizens. The first petition was written and sent on March 7, 1947 by Iwasaki Ichiro, a Japanese citizen who was captured in World War II and worked as a foreman in a woolen factory in Mongolia from 1945 to 1947. He wanted to stay and work in Mongolia. The application is now stored in the special archives of the General Intelligence Department of the State Government. The second one is the letter of Bai Guisheng, a Chinese citizen who threw his request application over the fence of the Mongolian embassy in Beijing in 1972. This document is stored in the Central Archives of Foreign Affairs.

I have transcribed these two petitions, presented their contents, and discussed the issue of whether Mongolia had the opportunity to accept the requests of those people within the framework of the laws in force at that time.

Ном зүй

1. УТА, Х. 383, д.1, хн.7
2. ГХТА, Ф-02, д.2, хн 422. х.11
3. Амарсанаа Ж. Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ., 2012
4. БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох актын эмхэтгэл (1941-1970) II боть. УБ., 1974
5. Давааням А., Мэндсайхан Х., Нэргүй Ц, ГИХАЭА-ны тогтолцоо, УБ., 2008
6. Дүгэрсүрэн М., Хосбаяр О. Олон улсын эрх зүй. УБ., 1999
7. Лүндэндорж Н. Төрийн онол. УБ., 2008
8. Мэндсайхан Х. МУ дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал, УБ., 2012
9. Пунцагдаш.О. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал). УБ., 2002
10. Урангуа Ж., Эрдэнэнбилэг.Б. Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд. УБ., 2018
11. “Хүний эрхийн нэр томъёоны товч толь”. УБ., 1996
12. Хүний эрхийн түгээмэл тунхаглал . НҮБ. 1948
13. Хүний эрхийн тухай үндсэн баримт бичгүүд. УБ., 1993
14. www.legalinfo.mn